



**ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2024 ОНЫ 1 ДҮГЭЭР
УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 4 сарын 12

Улаанбаатар хот

Тээвэр Хөгжлийн Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль, Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр Хөгжлийн Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон банкны дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 6 удаа хуралдаж хараат бус гишүүний хувьд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон.

Үүнд:

1. ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн №Т/24-01 дугаартай хурлаар “Банкны Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөө 2024-2028”-тэй танилцан, тус төлөвлөгөөг холбогдох журмын дагуу хугацаанд нь Монголбанканд хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон бөгөөд тус асуудлыг дэмжин, саналын зөрүү байгаагүй.
2. ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №Т/24-02 дугаартай хурлаар
 - Макро эдийн засгийн төлөв танилцуулах тухай
 - Банкны 2024 оны Бизнес төлөвлөгөө, төсөв, бүтэц зохион байгуулалт, орон тоо, цалингийн шатлалыг тус тус батлах тухай
 - Банкны ажилчдын 2023 оны ажлын гүйцэтгэлийн урамшуулал олгох эсэх тухай

- Банкны дотоод аудитын газрын 2024 оны бүтэц, орон тоо, ажлын төлөвлөгөө, төсөв батлах тухай
 - Банкны мэдээллийн технологийн бодлогыг шинэчлэн батлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд миний бие хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
3. ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №Т/24-03 дугаартай хурлаар:
- Банкны Гүйцэтгэх захирлын ирүүлсэн үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэх тухай
 - Банкны Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилох тухай
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан шинэчлэн батлах тухай асуудлуудыг хэлэлцэн, хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
4. ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн №Т/24-04 дугаартай хурлаар:
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба болон дотоод аудитын газрын ажилчдын цалинг шинэчлэн тогтоон батлах тухай
 - Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай асуудлуудыг хэлэлцэж, тус хурлын шийдвэрүүдийг дэмжиж, саналын зөрүү байгаагүй.
5. ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн №Т/24-05 дугаартай хурлаар:
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах эсэх тухай
 - Банкны холбогдох этгээд болох “**Алтай дожинт**” ХХК-д банкны борлуулах зориулалттай хөрөнгө дансанд бүртгэлтэй 133 ширхэг хөдлөх хөрөнгийг **8,348,460,000 (найман тэрбум гурван зуун дөчин найман сая дөрвөн зуун жаран мянга)** төгрөгөөр борлуулахыг зөвшөөрөх саналыг дэмжсэн ба холбогдох журмын дагуу хараат бус гишүүний дүгнэлт, зөвлөмжийг тусгасан болно.
6. ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн №Т/24-06 дугаартай хурлаар тус банкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн ба тус ээлжит хурлаар банкны 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах; хөндлөнгийн аудитын 2023 оны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дүгнэлтийг батлах; ногдол ашиг хуваарилах эсэх тухай тус тус асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэн санал нэгтгэйгээр дэмжин баталсан.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны
хуралд оролцсон байдал**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурал нь 2024 оны 1 дүгээр улиралд нийт 2 удаа хуралдаж хараат бус гишүүний хувьд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй, санал дүгнэлтийг гарган оролцсон.

1. 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн №01/2024 дугаартай хорооны хурлаар мэдээллийн технологийн газарт хийсэн шалгалтын тайлан танилцуулах тухай
 - Комплаенсийн газарт хийсэн шалгалтын тайлан танилцуулах тухай
 - Сакура салбар болон Мөнх тауэр салбарт хийсэн шалгалтын тайлан танилцуулах тухай
 - Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх 2023 оны 4 дүгээр улирлын тайлан танилцуулах тухай

Тус хурлаар дээрх асуудлуудыг хэлэлцэн, доорх санал, дүгнэлтийг гаргаж ажилласан:

- Тээвэр Хөгжлийн Банкны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг буюу /KPI/-д суурилж мэдээллийн технологийн газрын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг боловсруулж, дараагийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал эсхүл түүний дэргэдэх Аудитын хорооны хуралд танилцуулахыг
 - Мэдээллийн технологийн ерөнхий хяналт, удирдлагын тогтолцоо буюу COBIT-ийн талаарх сургалтыг банкны хэмжээнд 2 түвшинд буюу Банкны ТУЗ-ийн гишүүдэд, мөн банкны Мэдээллийн технологийн газрын нийт багийнхан, С түвшний бүх удирдлагуудыг хамруулан зохион байгуулахыг
 - Генератор хэвийн ажиллах тал дээр үйл ажиллагаанд нь анхаарч, тасалдал үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж маш сайн анхаарч ажиллах, чек-лист гарган гар тест хийж байхыг
 - Хяналтын самбар буюу Dashboard-г орчин үетэй хөл нийлүүлэх үүднээс realtime dashboard болгох талаар судалж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах, мэдээллийн технологийн газар нь бусад бизнесийн нэгжүүдтэй хамтран ажилладаг байхад анхаарах, банкны хяналтын системийг сайжруулахад анхаарч ажиллахыг
 - Мэдээллийн технологийн газрын хүний нөөцийн асуудлыг аутсорсинг хийх байдлаар гарц гаргалгаа хайж, ажлын гүйцэтгэлийг сайжруулахад анхаарахыг
- Хүний нөөцийн газар, Мэдээллийн технологийн газруудад тус тус үүрэг болгов.

- Комплаенсийн газрын ажлуудыг автоматжуулахад анхаарах
 - Ажилтнуудын ажлаас гарах явц их байгаа тул цаашид анхаарч ажиллахыг тус тус үүрэг болгов.
 - Банкны салбарын ажилчдын сургалтын явцыг сайжруулах, хийгдэж буй сургалт бүрт шалгалт авдаг, аттестачлал хийдэг болоход анхаарч ажиллах.
2. 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн №02/2024 дугаартай хорооны хурлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах эсэх тухай асуудлыг хэлэлцэж, шаардлагатай дүгнэлт, зөвлөмжийг гарган ажилласан. Үүнд:

Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Удирдлагын хорооны 2024 оны 3 дугаар сарын 14-ний №01_01/15-03, №01_01/15-06 дугаартай шийдвэрүүдийн дагуу "Алтай Логистик" ХХК-тай дараах барааг худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. Үүнд:

- Нийт 75,000,000 (далан таван сая) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий 1200 ширхэг картын хайрцаг худалдах, худалдан авах;
- Нийт 127,160,000 (нэг зуун хорин долоон сая нэг зуун жаран мянга) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий харилцагчийн бэлэг болох 300 ширхэг гоёл чимэглэлийн хайрцаг, 500 ширхэг түлхүүрийн хайрцаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд оролцсон байдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь 2024 оны 01 дүгээр улирлын байдлаар 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр нэг удаа хуралдсан. Тус хурлаар банкны эрсдэлийн нэгдсэн тайлан болон тусгай активын нэгжийн тайлан болон холбогдох этгээдэд борлуулах зориулалттай хөрөнгө дансанд бүтгэлтэй 133 ширхэг хөдлөх хөрөнгийг борлуулахыг зөвшөөрч, тус асуудлыг журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх саналыг гарган ажилласан.

Тайлан бэлтгэсэн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
Хараат бус гишүүн



Б.Оюунцацрал